



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/257

Улаанбаатар хот

Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн 12.3, 25.3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журмыг хавсралтаар баталж 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журмын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Стандартчилал, тохирлын үнэлгээ бодлогын газар (Г.Өнөржаргал)-т үүрэг болгосугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн даргын 2007 оны 213 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх, түр хэрэглэх зөвшөөрөл олгох” журмыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА

Г.ГАНТОМОР



023011957

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2018 оны 07 дугаар сарын 20 өдрийн
1/20.....дугаар тушаалын хавсралт



Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журам

1. Нийтлэг үндэслэл

1.1 Холбогдох хууль тогтоомж, норматив баримт бичиг болон хэрэглэгчийн эрх ашигт харшлахгүй, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахгүй олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартыг аж ахуйн нэгж байгууллагад хэрэглүүлэхээр бүртгэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Гадаадын стандарт бүртгэх журмын зорилго нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 12.3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд оршино.

1.3 Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журам нь нийтэд адил тэгш, нээлттэй үйлчилнэ.

2. Гадаадын стандарт бүртгэхэд тавих шаардлага

2.1 Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэхийг хүсэгч аж ахуйн нэгж байгууллагууд нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

2.1.1 Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх тухай өргөдлийг 1 дүгээр хавсралтын дагуу ирүүлэх;

2.1.2 Бүртгүүлэн хэрэглэхийг хүссэн Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэд стандартын эх хувь;

2.1.3 Стандартын орчуулгын баталгаажуулсан хувь;

2.2 Аж ахуйн нэгж, байгууллага нь гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдэлд заасан хугацааны дотор үндэсний стандартын төслийг боловсруулж, батлуулах үүрэгтэй.

2.3 Тухайн стандартыг нэг удаа бүртгүүлэн хэрэглэхээр зөвшөөрөл авсан тохиолдолд дахин бүртгүүлэн хэрэглэх зөвшөөрөл олгохгүй.

2.4 Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад улс руу гаргах (экспорт) тохиолдолд:

2.4.1 Аж ахуйн нэгж, байгууллага нь үндэсний стандартын төсөл боловсруулж, батлуулах үүрэг хүлээхгүй;

2.4.2 Гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдэлд хугацаа заахгүй;

2.4.3 Хэрэглэх хугацаанд эх стандарт нь өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр бүртгүүлэх үүрэг хүлээх;

3. Гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдэл олгох

3.1 Байгууллага, аж ахуйн нэгжид гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдэл олгох, стандартын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг Стандартчиллын асуудал хариуцсан нэгж хариуцна. Гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдлийг 2 дугаар хавсралтад заасны дагуу олгоно.

3.2 Стандартчиллын асуудал хариуцсан нэгж нь уг журмын 2.1-д заасан материалыг хүлээн авч дараах шаардлага хангасан тохиолдолд уг стандартыг бүртгэх асуудлыг ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.2.1 Тухайн стандарт хүчинтэй эсэх;

3.2.2 Тухайн стандарт үндэсний стандартаар батлагдсан эсэх;

3.2.3 Тухайн стандартыг бүртгүүлэн хэрэглэхийг хүсэгч аж ахуйн нэгж байгууллага нь Олон улсын гадаад орны өмнө хүлээсэн үүргийг гэрээгээр хамгаалсан эсэх;

3.3 Стандартчиллын асуудал хариуцсан нэгж нь уг журмын 2.1 болон 3.2 дахь заалтын шаардлага хангаагүй тохиолдолд албан ёсны хариуг бичгээр өгнө.

3.4 Тухайн стандартыг үндэсний стандартаар батлуулахад шаардагдах үе шат, хөдөлмөр зарцуулалтаас хамаарч гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдлийг 18 сар хүртэлх хугацаагаар олгоно.

3.5 Гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдэл олгосон бүртгэлийг 3-р хавсралтыг дагуу хөтөлнө.

3.6 Гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдлийг Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга баталгаажуулна.

-----//-----

(норматив)

Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх тухай өргөдөл

..... оны дугаар сарын Дугаар хот
-ны өдөр

Стандартчилал, хэмжилзүйн газарт

1. Тус байгууллага буюу..... нь хууль тогтоомж, үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн эрх ашигт харшлахгүй, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахгүй олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилттэй дараахь стандартуудыг хэрэглэх шаардлагатай байгаа тул тэдгээрийг хэрэглүүлэхээр бүртгэж өгнө үү.

| д/д | Хаанахын стандарт, түүний бүрэн тэмдэглэгээ, дугаар, нэр: – эх хэлээр нь – монгол хэлээр | Хэрэглэх зориулалт | Хэрэглэх хугацаа |
|-----|------------------------------------------------------------------------------------------|--------------------|------------------|
| | | | |
| | | | |
| | | | |

2. Дээр дурдсан стандартын эх хувь, Монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг тус бүр нэг хувь хавсаргав.

3. Хэрэглэх хугацаанд эх стандарт нь өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр бүртгүүлэх үүргийг хүлээнэ.

.....

(Албан тушаалтан, түүний гарын үсэг, нэр)

Гадаадын стандарт хэрэглэх тухай бүртгэлийн мэдэгдэл

..... оны дугаар сарын
.....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

1. “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлийн 3 дах хэсэг болон хууль тогтоомжийн бусад актыг үндэс болгон олон улсын дараахь стандартуудыг..... хэрэглэхийг бүртгэн авав.

| Д/ д | Стандарт, аргачлал, зааврын тэмдэглэгээ, дугаар, нэр: – эх хэлээр нь – монгол хэлээр | Хэрэглэх зориулалт | Хэрэглэх хугацаа | |
|---------|--------------------------------------------------------------------------------------|--------------------|------------------|--------|
| | | | эхлэх | дуусах |
| | | | | |
| | | | | |

ТАЙЛБАР: Стандарт хэрэглэхээр бүртгүүлэгч нь дараахь үүргийг хүлээсэн болно.

1. Хэрэглэх хугацаанд эх стандарт нь өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр бүртгүүлэх үүргийг хүлээнэ.

ДАРГА

ГАРЫН ҮСЭГ

